



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

2019 ОНЫ 07 ДУГААР САРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

АГУУЛГА

НЭГ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

1.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаар	3
1.2. Өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлтийн талаар	3
1.3. Санхүү, хөрөнгө оруулалтын талаар	4
1.4. Хяналт шалгалтын талаар	5

ХОЁР. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР:

2.1. Хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох талаар.....	6
2.2. Хууль, шүүхийн байгууллагад төлөөлөн оролцсон ажлын талаар	6
2.3. Стандарт, нормативийн талаар	7

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗАРТ ТАВЬЖ ШИЙДВЭРЛҮҮЛСЭН БОЛОН ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДАЛ:

7

ДӨРӨВ. САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

8

4.1. Авто замын талаар	8
4.2. Авто тээврийн талаар	9
4.3. Төмөр замын талаар	9
4.4. Агаарын тээврийн талаар	10

ТАВ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

11

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2019 ОНЫ 7 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ТОВЧ ТАЙЛАН

2019 оны 08 дугаар сарын 01

Улаанбаатар хот

Зам, тээврийн хөгжлийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, яамны үйл ажиллагааны стратеги зорилтын хүрээний бодлого, зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд яамны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

1.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаар:

Зам, тээврийн хөгжлийн яамны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу хөтлөн явуулж, яаманд ирсэн хариутай бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж, шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж, хариу өгөх хугацаа хэтэрсэн бичгийн мэдээг 7 хоног тутам гаргаж удирдлагуудад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Тус яаманд 2019 оны 07 дугаар сард нийт 894 бичиг ирснээс хариутай 412 бичиг, хариугүй 482 бичиг, шийдвэрлэсэн 206 нийт 14975 хуудас бичгийг сканердаж бүртгэл мэдээллийн санд оруулсан.

Ирсэн бичгийг удирдлагын цохолтоор Бодлого, төлөвлөлтийн газарт-236, Төрийн захиргааны удирдлагын газарт-208, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-117, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-91, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт-70, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэст-62, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт-90 бичиг шилжүүлсэн байна.

Яамнаас гадагш 609 албан бичиг явуулж 5300 хуудас сканердаж able программд оруулсан. Явуулсан бичгийг газар тус бүрээр ангилбал: Бодлого төлөвлөлтийн газар-182, Төрийн захиргааны удирдлагын газар-166, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-92, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-50, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар-52, Хяналт - шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар-23, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс-44 албан бичиг тус тус явуулсан байна.

1.2. Өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлтийн талаар:

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг цаг тухайд нь цахим болон дэвтрээр бүртгэн карталж удирдлагад танилцуулан холбогдох газар, хэлтэс, мэргэжилтэнд хувиарлан шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.

2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар яамны хэмжээнд иргэдээс нийт 38 өргөдөл ирснээс шийдвэрлэсэн 26, хяналтад 12, хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 68,4%-тай байна.

Хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй. Сар бүрийн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайланг Зам, тээврийн хөгжлийн яамны цахим хуудсанд байршуулж байна.

Иргэд болон албан хаагчдын санал, хүсэлтийг хүлээн авах “Санал хүсэлт”-ийн хайрцгийг 1 давхарт байрлуулан санал хүсэлтийг бүртгэх, хүлээн авах албан тушаалтныг томилон тогтмол ажиллуулж байна.

1.3. Санхүү, хөрөнгө оруулалтын талаар:

Албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажлын байрны бичиг хэргийн материалыг сар бүр захиалгын хуудсын дагуу захиалан тарааж байна. 2019 оны 07 дугаар сарын 31-ны байдлаар бичиг хэргийн зардал 17,949,047 төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх бараа материалын зардалд 7,504,897 төгрөг, шуудан, холбоо, интернэтийн төлбөрт 7,895,958.84 төгрөгийн зардлууд зарцуулагдаад байна. Мөн бусад техник хэрэгслээр цаг тухай бүр ханган ажиллаж байгаа болно.

Батлагдсан төсвийн зарцуулалтын эрхийн баталгааг үндэслэн 2019 оны 07 дугаар сард Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЭЗ/-ын багцын байгууллагуудын нийт 225 ширхэг 22,9 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээг “Төрийн сангийн төлбөр тооцооны систем”-д бүртгэн анхан шатны баримттай тулган шалгаж, төсвийн тухай хууль болон холбогдох журам дүрмийн дагуу төлбөр тооцоог хурдан шуурхай, үнэн зөв хийж гүйцэтгэн, хянан баталгаажуулж ажиллав.

Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЭЗ/-ын багцын байгууллагуудын 2019 оны 06 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч төсвийн хэлбэлзэлтэй тулган шалгаж, нэгтгэн Сангийн яаманд хүргүүлэв.

Засгийн газрын шилэн дансны хуудсанд яамны болон төсвийн ерөнхийлөн захирагчийн цалингийн зардлаас бусад таван саяас дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээ, хөрөнгө оруулалтын таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний мэдээ болон Сайдын багцын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хуулийн хугацаанд тайлагнав.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх 38 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг баталгаажсан гүйцэтгэл, банкны урьдчилгаа төлбөрийн баталгаанд үндэслэн Сангийн яамнаас эрх нээсний дагуу 2019 оны 07 дугаар сарын 31-ний байдлаар нийт 41,417.0 сая төгрөгийг гүйцэтгэгчийн дансанд олгов.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 288 дугаар тушаалаар баталсан улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын төлөвлөгөөний дагуу засвар, арчлалт хариуцагч төрийн өмчит болон хувийн хэвшлийн 32 компанитай байгуулсан гэрээг үндэслэн энэхүү компаниудад нийт 7,770.0 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг олгов.

Засвар арчлалт хариуцагч 31 компанийн хянагдаж, баталгаажсан гүйцэтгэлд үндэслэн Сангийн яамнаас эрх нээсний дагуу нийт 4,806.2 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгов.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын акт, ашиглагч байгууллагын тодорхойлолт зэрэг анхан шатны баримтыг үндэслэн Сангийн яамнаас эрх нээсний дагуу 24 төсөл, арга хэмжээ, барилгын ажлын нийт 2,072.8 сая төгрөгийн чанарын баталгаат хугацааны барьцаа хөрөнгийг чөлөөлж, гүйцэтгэгчид олгов.

Авто замын сангийн Төрийн сан дахь дансанд 2019 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар олон улс, улсын чанартай авто замаар зорчих авто тээврийн хэрэгслээс авах хураамжаас нийт 5,281.9 сая төгрөгийн орлого төвлөрч “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-аас ирүүлсэн Төлбөр авах цэгүүдийн 1-7 сарын үйл ажиллагааны санхүүжилтийн хүсэлтийг хянаж Авто замын сангаас нийт 1,254.1 сая төгрөгийн санхүүжилт олгов.

Норм, нормативын сангийн Төрийн сан дахь дансанд 2019 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга байгууламж, их засвар, зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээ, олон улс, улсын чанартай авто замын засвар арчлалтын ажлын гүйцэтгэлээс нийт 133.7 сая төгрөгийн орлого төвлөрсөн ба зарлага гараагүй байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны хөрөнгө оруулалтын 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гарган Сангийн яамны төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн цахим хуудсанд байршуулав.

Шилэн дансны тухай хуулийн хүрээнд 2019 оны 1-7 дугаар сарын “Сайдын багцын хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийн мэдээ”, “Яамны хөрөнгө оруулалтын таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний мэдээ”, “Цалингийн зардлаас бусад таван саяас дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээ” гарган www.shilendans.gov.mn сайтад байршуулав. Мөн “Сайдын багцын хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийн мэдээ”-г Зам, тээврийн хөгжлийн яамны веб хуудсанд байршуулав.

1.4. Хяналт шалгалтын талаар:

“Өег гурил” ХХК-ийн ирүүлсэн хүсэлтийн дагуу “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Толгойт өртөөнд шинээр салбар төмөр зам барих техникийн нөхцөл, боломжийг судлан түүний байршил, түвшинг тодорхойлж дүгнэлт гаргах ажлын хэсэгт Төрийн нарийн бичгийн даргын 236 дугаар тушаалын дагуу 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдөр ажиллаж салбар зам барих хүсэлтийг хүлээн авч техникийн албан даалгавар өгөв.

Төв аймгийн төвийн 2, 6 дугаар багт баригдсан 0,4км хатуу хучилттай авто зам, 16,2 у/м төмөрбетон гүүрийг ашиглалтад оруулах ажлын хэсэг 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдөр талбай дээр ажиллаж тус авто зам, төмөрбетон гүүрийг 100% саналаар ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 218 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн захиалгаар хэрэгжсэн “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн уурхайгаас Гашуунсухайтын авто замтай холбох 8.2 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг байнгын ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 216 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг Булган-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн 22 км авто замыг байнгын ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 421 дүгээр тушаалаар батлагдсан ажлын хэсэг 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр Аглаг бүтээллийн хийд хүртэлх 6,2 км хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулахаар талбай дээр дахин ажиллаж үүрэг даалаварын биелэлтээр ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

ХОЁР. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

2.1. Хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох талаар:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 219 дүгээр тушаалаар “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэв.

Автотээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дэх хэсэгт заасны дагуу “Хот хоорондын нийтийн тээвэрлэлтийн чиглэл, чиглэлийн зураглал батлах тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 232 дугаар тушаал батлагдсан бөгөөд уг тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яам хянан үзэж, улсын нэгдсэн бүртгэлийн 3793 дугаарт бүртгүүлж тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т 2019 оны 05/3815 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлтэй хөлөг онгоцонд техникийн үзлэг, шалгалт хийх үүрэг бүхий Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагыг томилох, түүний ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүн шинжилгээ хийх, үйл ажиллагааг хянан, зохицуулах журам, Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журмын төслийг боловсруулж, журмын төслийн танилцуулга, нөлөөллийн шинжилгээг боловсруулж байна. Мөн Усан замын тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9-д заасны дагуу “Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөр”-ийн төсөл, танилцуулга, журмын төслийн нөлөөллийн шинжилгээг боловсруулсан бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран батлуулахаар ажиллаж байна.

2.2. Хууль, шүүхийн байгууллагад төлөөлөн оролцсон ажлын талаар:

Зам, тээврийн хөгжлийн яамны нэхэмжлэлтэй “Нутгийн зам групп” ХХК-нд холбогдох иргэний хэрэгт Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 1216 дугаар магадлалыг эс зөвшөөрч Нийслэлийн хяналтын шатны шүүхэд хандан гомдлыг итгэмжлэгдсэн төлөөлөгч нар 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлж ажиллав.

Иргэн С.Дорждагвын нэхэмжлэлтэй Төрийн нарийн бичгийн даргад холбогдуулан гаргасан захиргааны хэргийн хурал 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдөр зарлагдаж гэрч асуух хүсэлтийн дагуу 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл хойшлогдов.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2009 онд нийлүүлэгдсэн автобусыг Аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр эзэмшүүлсэнтэй холбоотой төлбөр гаргуулах тухай нэхэмжлэлтэй “Мяралзаа” ХХК, “Тэнүүн Огоо” ХХК, “Сутайн буянт” ХХК, “Эрдэм Транс” ХХК-ийн иргэний хэргийн хурал зарлагдаж хэргийн оролцогчдын хүсэлтээр хурлыг жич товлохоор хойшлуулав.

“Жуулчин монгол наадам” ХХК-ийн нэхэмжлэлтэй Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдах Олон улсын нисэх онгоцны буудал баригдах газартай холбоотой Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн №154 дүгээр тогтоолын уртраг, өргөрөг өөрчлөгдсөнөөс өөрийн газарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулж, нөхөн төлбөр гаргуулах тухай” захиргааны хэргийн шүүх хурал 2019 оны 07 дугаар сарын 30-ны өдөр зарлагдаж шүүхээс Засгийн газрын 2010 оны 140, 2016 оны 154 дүгээр тогтоолуудыг 6 сарын хугацаанд түдгэлзүүлэхээр шийдвэрлэв.

2.3. Стандарт, нормативийн талаар:

“Авто замын тухай” хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 256 дугаар тушаалаар

- “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм” ЗЗБНБД 81-013-2019-г нэгдүгээр хавсралтаар,
- “Авто зам, замын байгууламжийн төсөв бодоход хэрэглэх ажилчдын цагийн тарифт цалингийн жишиг”-ийг хоёрдугаар хавсралтаар,
- “Авто зам, замын байгууламжийн машин механизмын ашиглалтын нэг машин цагийн үнэ”-ийг гуравдугаар хавсралтаар,
- “Автомашинаар ачаа тээвэрлэх 1 тн.км-ийн жишиг тариф”-ыг дөрөвдүгээр хавсралтаар,
- “Авто замын барилгын ажлын үйлдвэрлэлийн жишиг норм” БНБД 83-17-07, “Төмөрбетон гүүр, хоолойн барилгын ажлын үйлдвэрлэлийн жишиг норм” БНБД 83-4в-07, “Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын ажлын үйлдвэрлэлийн жишиг норм” БНБД 83-20-08, “Авто замын барилгын төсвийн жишиг норм” БНБД 81-25-07, “Төмөрбетон гүүр, хоолойн барилгын төсвийн жишиг норм” БНБД 81-28-07, “Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын ажлын төсвийн жишиг норм” БНБД 81-26-08 нормуудыг тавдугаар хавсралтаар,
- “Авто зам, гүүрийн арчлалт засварын ажлын зардлын суурь норм” зургаадугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталав.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗАРТ ТАВЬЖ ШИЙДВЭРЛҮҮЛСЭН БОЛОН ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДАЛ

Улаанбаатар-Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн 32.226 км хурдны авто зам ашигласны төлбөрийн хэмжээ тогтоох тухай асуудлыг 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, “Хурдны авто замын төлбөрийн хэмжээ тогтоох тухай” 282 дугаар тогтоолыг батлуулсан.

Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөрийг Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж “Хөтөлбөр батлах тухай” 283 дугаар тогтоолоор баталсан.

Тавантолгойн нүүрсний экспортын зохион байгуулалтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдөр 01/3948 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн 2019 оны хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны зардлын санхүүжилтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 01/3949 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн санхүүжилтийг шийдвэрлэх, барилгын ажлыг үргэлжлүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанд хэлэлцүүлэн дэмжигдсэн. Засгийн газрын тогтоол албажиж ирээгүй байна.

"Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-ын төсөлд Сангийн яамнаас дахин санал авч эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр 01/ 4029 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлээд байна.

ДӨРӨВ. САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

4.1. Авто замын талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан Улаанбаатар хот Хөшигийн хөндийн Олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг холбосон 32.226 км урт, асфальтбетон хучилттай, зорчих хэсгийн өргөн 31.0 м, 2 урсгал 6 эгнээ зорчих хэсэгтэй, олон улсын стандартад нийцсэн анхны хурдны авто замын бүтээн байгуулалтын ажлыг энэ онд дуусгаж, тус яамнаас томилогдсон Улсын комисс 2019 оны 07 дугаар сарын 03-наас 7 дугаар сарын 04-ний өдрийн хооронд ажиллаж, үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн бөгөөд Нээлтийн үйл ажиллагааг 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг Хөшигийн хөндий буюу хурдны авто замын төлбөр авах цэг дээр зохион байгуулав.

Завхан аймагт 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдрөөс 07 дугаар сарын 27-ны өдрийн хооронд ажиллаж, БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто зам, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажилтай танилцаж, өдөр тутмын барилгын ажлын явцад хяналт тавьж, эрчимжүүлэх талаар гүйцэтгэгч байгууллага болон зөвлөх компанийн төслийн удирдагч, хяналтын багт үүрэг даалгавар, чиглэл, зөвлөмж өгч, тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэв.

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын шинэчлэлийн ажлын хүрээнд Дархан-2 өртөөний дулааны шугам засварлах, Баруунхараа өртөөний усны шугам зөөж шилжүүлэх ажлын гэрээг Монгол Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгтэй байгуулж, засварын ажлыг эхлүүлсэн.

Олон улс, улсын чанартай авто замд 2019 онд хийгдэх урсгал засвар, арчлалтын ажил 60 хувьтай, батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна.

Он дамжин хэрэгжиж байгаа болон 2019 оны улсын төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалатаар шинээр баригдахаар гэрээ байгуулагдсан авто зам, гүүрийн барилга, их засвар, шинэчлэлтийн ажлын улаан шугам хүлээлгэх, ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох, ажил гүйцэтгэх график төлөвлөгөө батлах, график төлөвлөгөөний дагуу ажил гүйцэтгүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

4.2. Автотээврийн талаар:

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн дүрмийн 2.5-д заасны дагуу Үндэсний зөвлөлийн анхдугаар хурлыг зохион байгуулахаар төлөвлөж, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн хуралдааны хөтөлбөр, Зөвлөлмж, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх, уг сангаас мэдээлэл, лавлагаа өгөх журам, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шийдвэрийн төсөл, холбогдох хавсралтуудын хамт боловсруулан Үндэсний зөвлөлийн гийшүүдэд 2019 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 01/4056 дугаар албан бичгээр хүргүүлэв.

“Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-д оруулсан нэмэлт, өөрчлөлт болон бүртгэлийн шинэчилсэн програмыг нэвтрүүлэх асуудлаар “АТҮТ” ТӨҮГ-т газарт холбогдох чиглэлийг хүргүүлж ажиллав.

Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах Хамтарсан хорооны анхдугаар хурлыг 2019 оны 07 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд БНХАУ-ын Манжуур хотноо амжилттай зохион байгуулснаар хэлэлцээр хэрэгжиж эхэлсэн.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө” Зүүн Азийн Япон, БНСУ, БНХАУ, Хонконг, Монгол Улсын залуучуудын 3 өдрийн чуулга уулзалтыг МУЗН-тэй хамтран зохион байгуулж, илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 230 дугаар тушаалаар “Замт моторс” ХХК-д Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, “Олон улсын худалдаа логистикийн төв” ХК-ийн байршилд автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, “Мэндийн говь” ХХК, “ДБУ” ХХК, “Эрчэс хурд транс” ХХК, “Хан шанью” ХХК, “Хан модун” ХХК-уудад тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл тус тус олгов.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 163 дугаар тушаалаар түдгэлзүүлсэн “Альфа солбилцол” ХХК, “Жи Эл Ти” ХХК, “Төгрөг дугаар” ХХК /Баянзүрх/, “Аталар” ХХК, “Өгөлэд хайрхан” ХХК, “Рэс” ХХК, “Ньюпрезидент холдинг” ХХК-уудын тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг сэргээв.

Тээврийн хэрэгслийн бүртгэлийн шинэ системийг нэвтрүүлэх ажлыг “АТҮТ” ТӨҮГ-тай хамтран зохион байгуулав. Уг ажлын хүрээнд тээврийн хэрэгслийн дугаарыг иргэд, ААН байгууллагууд цахимаар захиалах боломжтой болсон ба бүртгэлийн шинэ системтэй зэрэгцэн улсын дугаарын шинэ серийг захиалганд оруулав.

4.3. Төмөр замын талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 10 дугаар тогтоолоор батлагдсан “Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замын шугамын чиг нь байгалийн нөөц газар болох Ханжаргалантаар дайран гарсныг өөрчлөх нөхцөл, шаардлага үүссэний дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 282 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Булган аймгийн Бугат сумын нутагт Эгийн голын усан цахилгаан станц төслийн авто зам, эрчим хүчний шугамын чиг байрлаж буй Хужирын голын хөндийгөөр тус төмөр замын чигийг зэрэгцүүлэн байрлуулах боломж, техникийн нөхцөлийг судалж дүгнэлт гаргах удирдамжийн дагуу 2019 оны 07 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд “Эгийн голын

усан цахилгаан станц” ХХК, “Нортерн Рейлвэйс” ХХК-ийн холбогдох удирдлага, мэргэжилтнүүдтэй хамтран Орхон, Булган аймгийн нутагт ажиллан дүгнэлт гаргасан.

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 215 дугаар тушаалаар байгуулагдсан хамтарсан ажлын хэсэг “Дархан-Сэлэнгийн Цахилгаан түгээх сүлжээ” ХК-ийн ирүүлсэн хүсэлтийн дагуу “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Зүүнхараа өртөөнд төмөр замын гол шугам болон салбар төмөр замтай цахилгааны кабель, агаарын шугам огтлолцуулах боломжийг судлан түүний байршил, цэгийг тодорхойлох ажлын хүрээнд 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдөр ажиллаж 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн №19/08 дугаар дүгнэлт гаргаж хүргүүлсэн.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос ирүүлсэн “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Толгойт өртөөнд авто замын нүхэн гарц байгуулах хүсэлтийг шийдвэрлэхээр Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 200 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн гол шугам төмөр замын Эмээлт-Толгойт хоорондын замын 389 дүгээр км-ын 8-аас 10 дугаар зуутын хооронд шинээр авто замын нүхэн гарцыг төмөр замтай ижил бус төвшинд огтлолцуулах боломжийг судлан, огтлолцлын төвшин, цэгийг тодорхойлон 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн №5 дугаартай дүгнэлтийг гарган Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 02/3502, 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 02/3799 тоот албан бичгүүдээр тус тус хүргүүлсэн.

Засгийн газрын 2016 оны 146 дугаар тогтоолоор батлагдсан Тавантолгой-Сайншанд чиглэлийн төмөр замын шугамын чигийн 290 дүгээр км хүртэл чигийг хэвээр үлдээж, 290 км-ээс Зүүнбаян өртөө хүртэлх 124 км газарт Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн төмөр замын чигийг шинэчлэн тогтоож “Төмөр замын шугамын чиг тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 232 тогтоол батлагдсаныг “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.1-дэх хэсэгт заасны дагуу дээрх шинэчлэн гарсан төмөр замын шугамын чигийг тусгай зөвшөөрлийн зураг зүйн бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг Уул уурхайн яам, Ашигт малтмал, газрын тосны газруудад Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 01/3584 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Усан замын тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 243 дугаар тушаалаар Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүсэлт ирүүлсэн 5 иргэнд олгов.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 209, 237 дугаар тушаалаар Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлсэн 13 компанийн өргөдлийн баримт бичгийн бүрдлийг хянан шалгаж хүсэлтүүдийг шийдвэрлэсэн.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 224, 241 дугаар тушаалаар Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагааны гэрчилгээ авах, сунгуулах хүсэлт ирүүлсэн 21 компанийн өргөдлийн баримт бичгийн бүрдлийг хянан шалгаж хүсэлтүүдийг шийдвэрлэсэн.

4.4. Агаарын тээврийн талаар:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 246 дугаар тушаалаар агаарын тээврийн “МИАТ” ТӨХК-ийг Хонг Конг, БНСУ, Япон Улс, Канад Улс, Австрали Улс, Сингапур Улс, БНЭУ, БНСВУ-ын иргэний нисэхийн удирдах

байгууллагууд хооронд тохирсон аяллын дугаар хуваан ашиглах зохицуулалтын дагуу эдгээр улсын нутаг дэвсгэрт нислэг гүйцэтгэх маркетингийн агаарын тээвэрлэгчээр томилов.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 248 дугаар тушаалаар агаарын тээврийн “Аэромонголиа” ХХК-ийг Улаанбаатар-Фукуока-Улаанбаатар, Улаанбаатар-Токио-Улаанбаатар, Улаанбаатар-Осака-Улаанбаатар нислэгийн чиглэлд тус тус нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр томилов.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 249 дүгээр тушаалаар агаарын тээврийн “Изинис Эйрвэйз” ХХК-ийг Улаанбаатар-Екатеринбург-Улаанбаатар нислэгийн чиглэлд нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр томилов.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 250 дугаар тушаалаар агаарын тээврийн “Изинис Эйрвэйз” ХХК-ийг Улаанбаатар-Истанбул-Улаанбаатар нислэгийн чиглэлд нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр томилов.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 251 дүгээр тушаалаар агаарын тээврийн “Изинис Эйрвэйз” ХХК-ийг Улаанбаатар-Макао-Улаанбаатар нислэгийн чиглэлд нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр томилов.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 252 дугаар тушаалаар Агаарын тээврийн “Хүннү Эйр” ХХК-ийг Улаанбаатар- Алма-Ата-Улаанбаатар нислэгийн чиглэлд нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр томилов.

ТАВ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭ

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Манжуур хотноо БНХАУ-ын Тээврийн яамнаас зохион байгуулагдаж буй “Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хорооны анхдугаар хуралд Зам тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар тус яамны төлөөлөлтэй 2019 оны 07 дугаар сарын 01-ээс 04-ний өдрүүдэд оролцож, мөн Монгол, Хятадын автотээврийн асуудлаарх хоёр талын уулзалт хийв.

Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд И.К.Азизовтой 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яаманд уулзалт хийв.

Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан Азийн хөгжлийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгч хатагтай Ёланда Фернандез Ломменийг 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдөр хүлээн авч уулзав.

Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын менежментийн концессын гэрээнд гарын үсэг зурах ёслолын үйл ажиллагааны 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдөр бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулав.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ